



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 06 өдөр

Дугаар А/288

Мөрөн сум

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга
хэмжээний ажлын жагсаалт, төсөвт
өртөг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, 41.2.6, 41.2.7, 65 дугаар зүйлийн 65.1.1 Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны ээлжит бус XIII хуралдааны 10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан “Мод тарьж ногоон суварга босгоё” аяны хүрээнд хашаа хайс барих, шинэчлэх” /Мөрөн сум/ арга хэмжээний хүрээнд хийгдэх ажлын жагсаалт, төсөвт өртгийг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан арга хэмжээний худалдан авах ажиллагааны холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газар (Б.Должинсорогдог)-т даалгасугай.

3. Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэхэд зарцуулагдах 500,000,000 (Таван зуун гучин сая) төгрөгийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн батлагдсан төсвөөс холбогдох хууль журамд нийцүүлэн гүйцэтгэлээр нь санхүүжүүлэх, төлөвлөгдсөн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж, хэрэгжилтийг тухай бүр тооцож, тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Оюунтуяа), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Базар) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын 2022 оны ...09
дугаар сарын ...05 -ны өдрийн .../288
дугаар захирамжийн хавсралт

“МОД ТАРЬЖ НОГООН СУВАРГА БОСГОЁ” АЯНЫ ХҮРЭЭНД
ХАШАА ХАЙС БАРИХ, ШИНЭЧЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
АЖЛЫН ЖАГСААЛТ ТӨСӨВТ ӨРТӨГ

Арга хэмжээ	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хөрөнгийн хэмжээ /сая төгрөг/	Санхүүжих дүн	
			2022	2023
“Мод тарьж ногоон суварга босгоё” аяны хүрээнд хашаа хайс барих, шинэчлэх	“Мод тарьж ногоон суварга босгоё аяны хүрээнд хашаа хайс барих, шинэчлэх /5 дугаар баг/	200,0	100,0	100,0
	“Мод тарьж ногоон суварга босгоё аяны хүрээнд хашаа хайс барих, шинэчлэх /8 дугаар баг/	300,0	200,0	100,0
Нийт дүн		500,0	300,0	200,0

_____оОо_____